

АЖЛЫН БАЙРНЫ ЗАР

Байршил: Налайх дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс

Эхлэх хугацаа: 2026/08/17

Дуусах хугацаа: 2026/08/31

Ажил эхлэх хугацаа: 2026/09

Цалин: Боловсрол, ажлын туршлагыг харгалзана.

Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2013 онд байгуулагдсан Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль (МГТИС) нь Монгол Улсын төрийн өмчит дээд боловсролын байгууллага юм. Тус сургууль нь Монгол Улсын болон ХБНГУ-ын Засгийн газрын дэмжлэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг.

ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ ИНЖЕНЕРИЙН БАГШ

Гүйцэтгэх үндсэн чиг үүрэг:

- GIS, Хөрс судлал, Геоэкологи, Уул уурхайн нөхөн сэргээлт, Хатуу хог хаягдлын технологи зэрэг мэргэшлийн чиглэлээр хичээл заах;
- Эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх;
- МГТИС-ийн бусад үйл ажиллагаанд оролцох.

Тавигдах шаардлага:

- Хүрээлэн буй орчны шинжлэх ухаан болон холбогдох чиглэлээр магистрын зэрэгтэй байх (Докторын зэрэгтэй бол давуу тал болно);
- Мэргэжлийн чиглэлээрээ 2-оос доошгүй жил ажилласан болон/эсвэл их, дээд боловсролын байгууллагад багшилсан туршлагатай байх;
- Англи хэлний ярианы болон бичгийн өндөр мэдлэгтэй байх;
- Олон соёлт орчинд ажиллах, харилцах чадвартай байх.

Бүрдүүлэх материал:

- Ажилд орох өргөдөл
- Товч намтар – CV
- Багшилсан туршлага, багшлах өөрийн арга барил, хандлагын талаарх мэдээлэл (тах. 2 хуудас)
- Өмнө нь хийсэн болон одоогийн судалгааны ажлын чиглэл, цаашдын сонирхлыг багтаасан мэдээлэл (тах. 2 хуудас)
- Эрдэм шинжилгээний бүтээлийн жагсаалт
- Мэргэжлийн ур чадварыг тодорхойлсон диплом, сертификат болон батламжийн хуулбар
- Тодорхойлолт өгөх хоёр хүний нэр, холбоо барих мэдээлэл

Холбоо барих:

✉ Та баримт бичгээ англи хэл дээр бэлтгэн 1 PDF файл болгон эмхэтгэж recruitment@gmit.edu.mn хаягаар бидэнд ирүүлнэ үү.

🌐 Хэрэв эх баримт бичиг нь англи хэлнээс өөр хэл дээр бол англи хэл рүү албан ёсоор баталгаажуулсан орчуулгыг хавсаргана.

☎ **Утас:** +976 7023-2090

🌐 **Цахим хуудас:** www.gmit.edu.mn

Жич: Зөвхөн шаардлага хангасан ажил горилогчидтой эргэн холбогдож ажлын ярилцлагад урих болно.